



2026 FEB

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

АГУУЛГА

I. СТАТИСТИКИЙН ТОЙМ1

II. ГАДААД ЭДИЙН ЗАСАГ2

2.1. Олон улсын эдийн засгийн нөхцөл байдал2

2.2. АНУ-ын эдийн засаг 2026 оны 2-р сард:3

2.3. БНХАУ-ын эдийн засаг 2026 оны 2-р сард:3

2.4. Түүхий эдийн зах зээл4

III. ДОТООД ЭДИЙН ЗАСАГ.....5

3.1. Эдийн засгийн өсөлт, инфляцын түвшин.....5

3.2. Өрхийн орлого ба зарлага6

3.3. Улсын төсөв7

3.4. Гадаад худалдаа8

3.5. Төлбөрийн тэнцэл, ханш.....11

ГРАФИК, ХҮСНЭГТҮҮДИЙН ЖАГСААЛТ

График 1 БНХАУ-ын үнийн индекс.....4

График 2 Түүхий эдийн үнийн төсөөлөл, 2026 оны эцэс хүртэл4

График 3 Монголын эдийн засгийн өсөлт 2019-2025.....5

График 4 Инфляц ба бодлогын хүү6

График 5 Өрхийн бодит орлого ба зардал7

График 6 Улсын төсвийн гүйцэтгэл8

График 7 Экспорт, импортын өсөлт8

График 8 Экспортын орлого.....9

График 9 Импортын бүтээгдэхүүн10

График 10 Нүүрсний экспортын биет хэмжээ.....10

График 11 Төлбөрийн тэнцэл, ГВАН, ханш11

I. СТАТИСТИКИЙН ТОЙМ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2025Q4	2025Q3	2024Q4	
Бодит ДНБ	тэрбум төгрөг	34,332	24,251	32,133	6.8%
Ажилгүйдлийн түвшин	%	5.6%	5.5%	5.3%	
Дундаж нэрлэсэн цалин	мянган төгрөг		2,714	2,672	
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026M1	2025M12	2025M1	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд					
Нийт экспорт	сая ам.доллар	1,749	15,701	1,019	72%
Зэс	сая ам.доллар	726	5,809	264	175%
Нүүрс	сая ам.доллар	625	5,561	449	39%
Нийт импорт	сая ам.доллар	843	-11,312	973	-13%
Хэрэглээ	сая ам.доллар	250	-3,519	344	-27%
Түүхий эд	сая ам.доллар	277	-4,696	352	-21%
Аж үйлдвэрлэл	сая ам.доллар	97	-960	70	39%
Шатахуун	сая ам.доллар	218	-2,118	206	5%
Тэнцэл	сая ам.доллар	906	4,389	46	19%
Түүхий эдийн үнэ					
Зэс	\$/тонн	13,158	12,423	9,048	45.4%
Нүүрс (хилийн)	\$/тонн	64.4	67.4	86.2	-25.3%
Алт	\$/трой унц	4,894	4,319	2,798	74.9%
Газрын тос	\$/barrel	69.3	60.9	70.3	-1.4%

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026M1	2025M12	2025M1	
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн тэнцэл	тэрбум төгрөг	-425	-1,232	-676	-13.7%
Төсвийн орлого	тэрбум төгрөг	1,706	30,058	1,668	2.2%
Төсвийн зардал	тэрбум төгрөг	31,289	27,379	30,591	2.3%
Мөнгөний бодлого					
M2 нийлүүлэлт	тэрбум төгрөг	47,054	45,801	43,276	8.7%
ХҮИ (C2023)	индекс	120.2	118.8	111.8	7.5%
Бодлогын хүү	%	12%	12%	10%	
Хүү ба ханш					
Ам долларын ханш (Эцсийн)	Төгрөг/\$	3,564	3,557	3,448	3.4%
Төгрөгийн хадгаламж	%	12.0%	12.0%	11.9%	
Валютын хадгаламж	%	3.6%	3.6%	4.1%	
Төгрөгийн зээл	%	17.2%	17.2%	16.9%	
Валютын зээл	%	9.8%	9.8%	9.6%	
Гадаад валютын нөөц					
Нийт	сая ам.доллар	6,738	7,005	4,884	38.0%

II. ГАДААД ЭДИЙН ЗАСАГ

2.1. Олон улсын эдийн засгийн нөхцөл байдал

Швейцарын Давос хотноо 2026 оны 1-р сарын 19-23-ны өдрүүдэд “Дэлхийн эдийн засгийн форум”-ын ээлжит уулзалт зохион байгуулагдаж, 130 орчим улсын 3000 гаруй улс төрчид, Төв банкны удирдлагууд, томоохон компанийн гүйцэтгэх захирлууд, мөн шинжээчид нэг дор цугларчээ. 2026 оны Давосын уулзалтаар дэлхий даяар өсөлт удааширч, өр нэмэгдэж, технологийн хувьсгал хурдасч, уур амьсгалын дарамт нэмэгдэж буй шилжилтийн үеийг онцоллоо.

- 2026 онд дэлхийн эдийн засгийн өсөлт ойролцоогоор 3 орчим хувь байх төлөвтэй байгаа нь цар тахлын өмнөх дундаж түвшнээс доогуур үзүүлэлт юм. Зарим бүс нутагт өсөлт сул хэвээр, ялангуяа Европын олон улсад үйлдвэрлэлийн салбар удааширалтай байгаа нь анхаарал татсан сэдэв байлаа. Өндөр өртэй орнуудын тоо нэмэгдэж, хөгжиж буй орнуудын төсвийн дарамт нэмэгдэж буй нь хэлэлцүүлгийн гол асуудлуудын нэг байв.
- Инфляцын түвшин олон оронд буурч эхэлсэн ч Төв банкнуудын 2 хувийн зорилтот түвшнээс дээгүүр хэвээр байна. Зарим том эдийн засагт инфляц 3 орчим хувьд хадгалагдаж байгаа нь бодлогын хүүг бууруулах эсэх асуудлыг төвөгтэй болгож байна. Зээлийн хүү өндөр хэвээр байгаа нь хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, өрийн үйлчилгээний зардлыг өсгөж байна.
- Геополитикийн хурцадмал байдал мөн чуулганы гол сэдэв байв. Худалдааны зөрчил, нийлүүлэлтийн сүлжээний тасалдал, стратегийн түүхий эдийн төлөөх өрсөлдөөн нэмэгдэж, “эдийн засгийн хуваагдал” (fragmentation) бодит эрсдэл болж байгааг онцолсон. Дэлхийн худалдааны өсөлт өмнөх арван жилийн дунджаас доогуур түвшинд хэлбэлзэж байгаа нь интеграц сулрах дохио гэж үзэж байна.
- Түүнчлэн хиймэл оюун ухааны хурдацтай хөгжил нэгэн чухал сэдэв болсон. Зарим тооцоогоор хиймэл оюун ухаан ойрын жилүүдэд дэлхийн ДНБ-д ихээхэн хувь нэмэр оруулах боломжтой ч хөдөлмөрийн зах зээлд томоохон өөрчлөлт авчрах эрсдэлтэй. Ажлын байрны бүтцийн өөрчлөлт, ур чадварын шинэчлэл зайлшгүй шаардлагатайг дурдлаа.
- Уур амьсгалын өөрчлөлт мөн адил чухал сэдэв байв. Сүүлийн жилүүдэд тохиолдож буй хэт халалт, үер, ой хээрийн түймэр нь эдийн засгийн шууд хохирлыг нэмэгдүүлж байна. Ногоон шилжилтийг санхүүжүүлэхэд жил бүр их наяд ам.долларын хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай гэж шинжээчид онцолсон. Гэвч эрчим хүчний аюулгүй байдал ба нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах зорилт хоорондын тэнцвэрийг олох нь амаргүй асуудал хэвээр байна.

Чуулганы гол дүгнэлтэд дэлхийн эдийн засаг илүү хуваагдсан, технологид тулгуурласан, уур амьсгалын эрсдэл өндөртэй шинэ бодит байдалд орж байгаа бөгөөд олон улсын хамтын ажиллагаа урьд өмнөхөөс илүү чухал боловч хэрэгжүүлэхэд улам хүндрэлтэй болж байгааг дурдав. (World Economic Forum, 2026)



Мөн Давосын хуралд Монгол Улс АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампын санаачилсан Энхийн зөвлөлд албан ёсоор нэгдэж, үүсгэн байгуулагч гишүүн улс болсныг Засгийн газраас мэдээллээ. Энхийн зөвлөлд Аргентин, Армен, Азарбайжан, Казахстан зэрэг нийт 17 улсын төр засгийн тэргүүн, сайд нар гарын үсэг зурсан ба Монгол улс сайн дурын үндсэн дээр хамтран

ажиллах, улс орнуудын бүрэн эрхт байдлыг хүндэтгэх зарчмыг баримталж оролцож байгаагаа мэдэгдсэн нь нэгэн онцлох үйл явдал болов.


2.2. АНУ-ын эдийн засаг 2026 оны 2-р сард:

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампын импортын тарифын бодлогыг Дээд шүүхээс хууль бус гэж дүгнэж, хүчингүй болгов. Энэхүү шийдвэр нь АНУ-ын импортлогчдын төлсөн тарифыг буцаан олгохтой холбоотой хууль эрх зүйн асуудлыг хурцатгах төлөвтэй байна. Өнгөрсөн онд АНУ-тай худалдааны хэлэлцээр хийгээгүй орнуудад суурь 10 хувиас 41 хувь хүртэлх дүнтэй тариф ногдуулж байсан. Иймд тарифын бодлогыг хууль бус гэж Дээд шүүх үзсэнээр Дональд Трампын засаг захиргаа 2025 оны шийдвэрийн хүрээнд импортоос үргэлжлүүлэн тариф авах боломжгүй болох, мөн өмнө нь тариф төлсөн импортлогчдод буцаан олголт өгөх шаардлагатай тулгарч байна. Тарифыг цуцалснаар АНУ-ын засгийн газрын төсөв хүндрэлд орох эрсдэлтэй. Дээд шүүхийн шийдвэрээр 2026 оны 2 сарын 24-с эхлэн дэлхийн бүх улсад 10 хувийн шинэ тариф ногдуулах захирамж гаргасан. Ийнхүү Канад, Европын орнууд тарифын хувь хэмжээг эсэргүүцэж эхэлж байна. /АНУ-ын тарифын орлого 2025 онд 287 тэрбум ам.доллартой тэнцэж байгаа бол импортлогчдод буцаан олгох нийт дүн 170 тэрбум ам.доллартой тэнцэж байна/ (Federal Reserve bank of Richmond, 2026)

2.3. БНХАУ-ын эдийн засаг 2026 оны 2-р сард:

БНХАУ-ын аж үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 5.9%-р өсөж, жижиглэнгийн худалдаа 4%-р нэмэгдсэн нь үйлдвэрлэл болон хэрэглээ харьцангуй тогтвортой байгааг харуулж байна. Гэвч 2026 оны 2-р сарын байдлаар гадаад худалдааны өсөлт саарч, экспорт ердөө 2.3%-р өссөн бол импорт 8.4%-р буурчээ. Тухайн хугацаанд хэрэглээний үнийн индекс (CPI) 0.2%-р өсөж дефляцийн дарамт үргэлжлэх, үйлдвэрлэгчдийн үнийн индекс 1.4 хувиар буурсан зэрэг нь эдийн засгийн идэвхжил сул байгааг илтгэж байна.


График 1 БНХАУ-ын үнийн индекс



2.4. Түүхий эдийн зах зээл

Монгол улсын хувьд гол нөлөө үзүүлж буй алт, зэс болон коксжих нүүрсний үнийн 2026 оны эцэс хүртэлх үнийн төсөөллийг График 2-т харууллаа. Алтны үнэ 2026 оны 2 сарын 24-ний байдлаар 5,170 ам.доллар/унцтай тэнцэж байгаа бол зэс 12,869 ам.доллар/тн, Австралийн коксжих нүүрс 245 ам.доллар/тн-той тэнцэж байна. Bloomberg Terminal дэх мэдээллээр алтны үнэ Төв банкнуудын худалдан авалт болон худалдааны дайны эрсдэлээс шалтгаалж одоогийн спот ханшаас оны эцэст гэхэд 3.9 хувиар, зэсийн үнэ 0.7 орчим хувиар өснө гэсэн хүлээлттэй байна. Харин Австралийн коксжих нүүрсний хилийн үнэ одоогийн ханшаас 9.3 хувиар буурах хүлээлттэй байгаа нь БНХАУ-ын гангийн эрэлт буурч байгаатай холбоотой байна.

График 2 Түүхий эдийн үнийн төсөөлөл, 2026 оны эцэс хүртэл




III. ДОТООД ЭДИЙН ЗАСАГ

3.1. Эдийн засгийн өсөлт, инфляцын түвшин

Эдийн засгийн өсөлт 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 6.8% гарч, олон улсын байгууллагуудын дундаж төсөөллөөс давлаа. Тухайлбал, ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг байгууллагуудын дундаж төсөөллөөр Монгол улсын эдийн засгийн өсөлт 2025 онд 5.8% гарах хүлээлттэй байсан юм.

График 3 Монголын эдийн засгийн өсөлт 2019-2025



2025 оны эдийн засгийн өсөлт хүлээлтээс ийнхүү өндөр гарахад уул уурхайн салбарын өсөлт хүлээгдэж байснаас өндөр гарсан нь голлон нөлөөлжээ. Тухайлбал уул уурхайн салбарын бодит өсөлт өмнөх оны мөн үеэс 10.6%-аар өсөж, эдийн засгийн өсөлтөд 1.4 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлсэн байна.

Оны сүүлийн хагаст нүүрсний экспорт сэргэж, Оюу толгойн далд уурхайн үйлдвэрлэл эхэлсэнтэй холбоотой зэсийн баяжмалын агууламж сайжирсан зэрэг нь уул уурхайн салбарын өсөлтийг тайлбарлаж байна. Мөн 2025 онд цаг агаар, зудын нөхцөл байдал тогтвортой байснаар хөдөө аж ахуйн салбарын өсөлт өмнөх оны зудын хүндрэлээс сэргэж, 33.2%-аар өссөн нь эдийн засгийн өсөлтөд 2.9 нэгж хувийн эерэг нөлөө үзүүллээ.

Хүснэгт 1 Эдийн засгийн өсөлтөд салбаруудын оролцоо

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, САЛБАРААР	Оролцоо	Жилийн өсөлт
ДНБ	6.8%	
ХАА	2.9%	33.2%
Уул уурхай	1.4%	10.6%
Боловсруулах	0.7%	10.0%
Цахилгаан, хий, уур, усан хангамж	0.2%	9.4%
Барилга	0.5%	15.9%
Бөөний, жижиглэн худалдаа	-0.6%	-4.6%


Тээвэр	0.3%	4.8%
Мэдээлэл холбоо	0.2%	7.2%
Үйлчилгээний бусад	1.0%	3.5%
Бүтээгдэхүүний цэвэр татвар	0.04%	0.3%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) 2026 оны нэгдүгээр сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.5%, өмнөх сараас 1.1%-аар өслөө. Ийнхүү хоёр сар дараалан инфляц Төв банкны зорилтод интервалд хадгалагдан буурахад төрийн зохицуулалттай бараа үйлчилгээний буюу цахилгааны үнийн өсөлтийн нөлөө арилсан нь голлон нөлөөлжээ. Жилийн инфляцыг барааны бүлгээр задлан авч үзвэл хүнсний бараа, ундаа, усны үнэ болон боловсролын үйлчилгээ хамгийн өндөр буюу өмнө оны мөн үеэс тус тус 12.6% болон 12.8%-аар өсжээ. Мөн үнийн өсөлтийг оролцооны хувиар авч үзэхэд 3.4 нэгж хувийг хүнсний инфляц бүрдүүлсэн бол 0.9 нэгж хувийг хувцас, бөс бараа, гутлын үнийн өсөлт бүрдүүлжээ.

Хэдий инфляц алгуур буурч байгаа ч Монголбанкнаас инфляц хөөрөгдөх эрсдэлийг харгалзан үзэж оны эхнээс мөнгөний хатуу бодлогын олон талт арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн энэ оны дунд үе хүртэл мөнгөний хатуу бодлогын төлөвийг хадгалах хүлээлттэй байна.

График 4 Инфляц ба бодлогын хүү



3.2. Өрхийн орлого ба зарлага

2025 оны 4-р улирлын байдлаар нэг өрхийн сарын дундаж орлого 3.0 сая төгрөг болж өмнөх оноос 14.1%-аар өсчээ. Харин инфляцаар засварласан бодит орлого 5% өссөн байна. Нөгөө талдаа өрхийн нэрлэсэн зардал мөн 3.1 сая төгрөг болж 14.1%-аар өссөн бол бодит өсөлт мөн 5% байна. Хэдийгээр цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж зэргээр иргэдийн нэрлэсэн орлого нэмэгдэж байгаа ч нөгөө талдаа бараа бүтээгдэхүүний

үнийн өсөлт өндөр байгаа нь ийнхүү өрхийн бодит худалдан авах чадвар бага байхад нөлөөлж байна.

Нэг өрхийн бодит мөнгөн орлогын бүрдлийг харвал 57.5% нь цалин, 21.2% нь тэтгэвэр тэтгэмж, 7.9%-ийг ХАА-н орлого, үлдсэн 13.4%-ийг бусад орлого бүрдүүлж байна. Цаашлаад өрхийн нэрлэсэн орлого Улаанбаатар хотод дунджаар 3.4 сая төгрөг байгаа нь аймгийн төвөөс 20.8%, сумын төвөөс 32.8%, хөдөө нутгаас 37.0%-аар тус бүр өндөр дүн болж байна.

График 5 Өрхийн бодит орлого ба зардал




Харин нэг өрхийн мөнгөн зарлагын бүтцийг авч үзвэл, 69.6%-ийг хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага, 17.3%-ийг хүнсний бүтээгдэхүүний зарлага бүрдүүлж байна. Мөн хотын өрхүүдийн сарын дундаж нийт зарлага орон нутгийн өрхүүдээс 725.2 мянган төгрөг буюу 27.8%-иар өндөр байна.

3.3. Улсын төсөв

2026 оны 1-р сард улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1.7 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2.2%-иар өслөө. Нийт тэнцвэржүүлсэн орлогын 93%-ийг татварын орлого бүрдүүлж байгаа бөгөөд татварын орлогын 26.3%-ийг орлогын албан татвар, 29.5%-ийг НӨАТ, 24%-ийг нийгмийн даатгалын орлого тус бүр бүрдүүлж байна.

Татварын орлого өмнөх оноос 9.3%-иар буюу 135.8 тэрбум төгрөгөөр өсөхөд НӨАТ-ын орлого өмнөх онтой харьцуулахад 58.5%-иар буюу 173.3 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн бол онцгой албан татвар 50.3%-иар буюу 56.9 тэрбум төгрөгөөр буурсан нь сөргөөр нөлөөлжээ. АМНАТ-ын орлого 2026 оны 1-р сард 26.9 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа ба өмнө жилийн мөн үеэс 72 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

График 6 Улсын төсвийн гүйцэтгэл




Улсын төсвийн зардал 2026 оны 1-р сард 2.1 их наяд төгрөг болж өмнөх оноос 1.4%-иар буурсан байна. Зарлага буурахад хүүгийн зардал өмнөх оны мөн үеэс 87.8 тэрбум төгрөгөөр буюу 40.3%-иар, засгийн газрын урсгал шилжүүлэг 96.6 тэрбум төгрөгөөр буюу 33.5%-иар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ. Харин бараа үйлчилгээний зардал болон бусад урсгал шилжүүлгүүд тус бүр 13.1%, 17.5%-иар өссөн байна. Улмаар төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 425 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 13.7%-иар буюу 67.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.

3.4. Гадаад худалдаа

2026 оны нэгдүгээр сарын гүйцэтгэлээр экспортын өсөлт 71.6%-д хүрсэн бол импорт 12.6%-ийн бууралттай гарчээ.

График 7 Экспорт, импортын өсөлт



Нийт экспортын орлого 730 сая ам.доллараар өсөж 1.8 тэрбум ам.долларт хүрсэн ба үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 458 сая ам.доллар, тоо хэмжээнээс шалтгаалж 275 сая ам.долларын нэмэгдэл орлого бий болсон байна.

График 8 Экспортын орлого




Экспортын орлогыг голлох бүрэлдэхүүнээр задлан авч үзэхэд зэсийн экспорт тэргүүлэх түүхий эд хэвээр буюу нийт орлогын 41%-ийг дангаар бүрдүүлжээ. Харин нүүрсний экспортын хувьд чулуун нүүрсний биет хэмжээ 9.7 сая тонн-д хүрсэн нь өмнө оны 5.2 сая тонноос өндөр гүйцэтгэл боллоо. Улмаар нүүрсний экспортын орлого өмнө оны мөн үеэс 39%-аар өсөж 625 сая ам.долларт хүрснээр нийт экспортын орлогын 36%-ийг бүрдүүлжээ.

Цаашлаад олон улсад геополитикийн тодорхойгүй байдал үргэлжилж хөрөнгө оруулагчдын хувьд аюулгүй хөрөнгө оруулалтын хэрэгсэл болох алтны худалдан авалтыг нэмэгдүүлж байгаа тул алтны үнэ өсөлттэй хэвээр байна. Тухайлбал 2026 оны 1-р сарын байдлаар алтны үнэ олон улсад дунджаар нэг унц тутамд 4,894 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 74.9%-аар өссөн ба Монгол улсын алтны экспортын орлого өмнө оноос 135.2%-аар өсөж 167 сая ам.долларт хүрчээ.

График 9 Импортын бүтээгдэхүүн

Импортын голлох бүтээгдэхүүний зардал-2026 1 сар

жилийн өсөлт, зардлын хэмжээ



Эх сурвалж: Монголбанк

Дотоод эрэлтийн идэвхжил өмнөх оноос суларч импортын зардал бууралттай гарлаа. Тухайлбал 2026 оны 1-р сарын байдлаар нийт импортын зардал өмнөх оны мөн үеэс 130 сая ам.доллараар буюу 13%-аар буурч 843 сая ам.долларт хүрчээ.

Импортыг голлох бүтээгдэхүүнээр задлан авч үзэхэд хөрөнгө оруулалтын барааны импорт өмнө оны мөн үеэс 21.3%-аар буурч 277 сая ам.долларт хүрсэн ба хэрэглээний бүтээгдэхүүний импорт мөн 27.3%-аар буурч 250 сая ам.долларт хүржээ.

График 10 Нүүрсний экспортын биет хэмжээ

Нүүрсний экспортын биет хэмжээ, хилийн үнэ

сарын цэвэр




Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Ийнхүү 2026 оны эхнээс гадаад худалдааны статистик экспортын өсөлттэй, импортын бууралттай гарснаар худалдааны тэнцэл 906.5 сая ам.долларын ашигтай буюу өмнө оны мөн үеэс 19 дахин өссөн байна.

3.5. Төлбөрийн тэнцэл, ханш

Гадаад худалдааны ашиг 2025 оны сүүлийн саруудад нэмэгдсэнээр 2025 оны эцэст худалдааны хуримтлагдсан алдагдал буурч 2.2 тэрбум ам.долларт хүрчээ. Мөн бондын хөрөнгө оруулалт нэмэгдэж валютын орох урсгал сайжирснаар санхүүгийн дансны ашиг 2025 оны хуримтлагдсан дүнгээр 3.3 тэрбум ам.долларт хүрч, төлбөрийн тэнцэл оны эцэст 1 тэрбум ам.долларыг давсан нь 2024 онтой харьцуулахад үнэмлэхүй сайжирсан үзүүлэлт боллоо.

График 11 Төлбөрийн тэнцэл, ГВАН, ханш



Эх сурвалж: Монголбанк

2026 оны 1-р сард гадаад валютын албан нөөц (ГВАН) 6.7 тэрбум ам.долларт хүрсэн буюу дунджаар 8 сарын импортыг хангах хэмжээнд байна. Хэдий ГВАН өндөр хэмжээнд хадгалагдаж байгаа ч өмнөх сарын 7 тэрбум ам.доллараас буурсан ба төгрөгийн ханшийн хувьд өмнө сараас ялимгүй сулраад байна. Тухайлбал 2026 оны 1-р сарын эцэст нэг ам.доллар 3,564 төгрөгтэй тэнцэж байгаа нь өмнөх сараас 7 төгрөгөөр, өмнө оны мөн үеэс 132 төгрөгөөр чангарсан үзүүлэлт болжээ.



ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

☎ 7575-1111 /1277/
✉ eru@golomtbank.com
🌐 www.dua.golomtbank.com

📍 Голомт банкны төв байр,
Сүхбаатарын талбай 5, Ш/х-22,
Улаанбаатар 15160, Монгол Улс
SWIFT: GLMT MNUB

АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны алба нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.